



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 11 сарын 12 өдөр

Дугаар А/410

Мандалговь

Дундговь аймгийн уугуул
Монхор овогтой Намжилсүрэнд
буцалтгүй тусламж үзүүлэх тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 "г", Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тоот тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.6 дахь заалт, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2021 оны 11 дүгээр сарын 11-ний 16 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дундговь аймгийн уугуул Монхор овогтой Намжилсүрэн нь хүнд өвчний улмаас эмчийн хяналтад эмчилгээ хийлгэж байгаа тул тулгараад байгаа санхүүгийн хүндрэлтэй байдал, аймгийн Засаг даргад хандаж ирүүлсэн өргөдлийг харгалзан үзэж нэг удаагийн буцалтгүй тусламжийг үзүүлсүгэй.

2. Тусламжид шаардагдах 1.000.000 (нэг сая) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Л.Доржбат), нягтлан бодогч (М.Янжиндолгор) нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

481210502